



НИЙСЛЭЛИЙН ГАЗРЫН АЛБАНЫ
ДАРГЫН ТУШААЛ

2017 оны 12 сарын 12 өдөр

Дугаар 57251

Улаанбаатар хот

Ч.Энхцэцэгийг төрийн
албанаас түр чөлөөлөх тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дах заалт, Төрийн албаны тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.3.1, 23.5 дах заалт, 30 дугаар зүйлийн 30.4.4 дэх заалт, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дах заалт, Засгийн Газрын 2004 оны 112 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчид тусламж олгох нөхцөл журам"-ын 2 дах заалт, Хөдөлмөрийн дотоод журмын 9.13, 2.10 дах заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тус албаны Захиргааны хэлтсийн Хүний нөөцийн мэргэжилтэн Чинбатын Энхцэцэг нь биеийн эрүүл мэндийн байдлын улмаас 1 жилээс дээш хугацаагаар албан ажлаа хийхгүйгээр эмчлүүлж, сувилуулах шаардлагатай болсон тул хүсэлтийг нь харгалзан 2017 оны 12 дугаар сарын 13-ны өдрөөр тасалбар болгон төрийн албанаас түр чөлөөлсүгэй.

2. Ч.Энхцэцэгт Засгийн Газрын 2004 оны 112 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчид тусламж олгох нөхцөл журам"-ын 2 дах заалтын дагуу албан тушаалын 3 сарын цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн тусламжийг олгохыг Санхүү аж ахуйн хэлтэс, Ерөнхий нягтлан бодогч /Ц.Алтанцэцэг/-т зөвшөөрсүгэй.

3. Ажлыг нь хүлээлцүүлж, тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Захиргааны хэлтэс /Л.Цэцгээ/-т даалгасугай.

ДАРГА



Ө.БОЛОРЧУЛУУН